



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 364

Улаанбаатар хот

“Монголын гэгээ” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс
гаргасан саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 57.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.2, 34.1.8, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ын 2.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монголын гэгээ” ХК-ийн нийт гаргасан 271,805 ширхэг хувьцааны 77,75 хувь буюу 211,321 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох Г.Отгонбаяр, А.Гүррагчаа, Г.Энхбаатар, Г.Алимаа, Г.Энхтөр, Г.Бат-Эрдэнэ нараас тус хувьцаат компанийн бусад 719 хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 22,25 хувь буюу 60,484 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1,051 /нэг мянга тавин нэг/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног байхаар тогтоосугай.

2. “Монголын гэгээ” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргах ажиллагаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /Г.Отгонбаяр/-д үүрэг болгосугай:

1/ Компанийн тухай хуулийн 57.3-т заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт буюу 2013 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн дотор худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэх;


001892

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН